

## МОНГОЛЫН ЗАГАСЧЛАЛЫН СПОРТЫН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Монголын загасчлалын спортын холбоо (цаашид “МЗСХ” гэх) -ны удирдах зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулна.

### Хоёр. Удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн

- 2.1. МЗСХ-ны удирдах зөвлөл нь МЗСХ-ны гишүүдийн хурлаас дөрвөн (4) жилийн хугацаатайгаар сонгогдох бөгөөд МЗСХ-ны гишүүдийн хурлын хооронд үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 2.2. МЗСХ-ны удирдах зөвлөл нь есөн (9) гишүүнтэй байх бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
  - 2.2.1. Ерөнхийлөгч
  - 2.2.2. Ерөнхий нарийн бичгийн дарга
  - 2.2.3. Удирдах зөвлөлийн гишүүн долоон (7) хүн
- 2.3. Ерөнхийлөгч нь МЗСХ-ны гишүүдийн хурлаас дөрвөн (4) жилийн хугацаатайгаар сонгогдоно.
- 2.4. Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгч томилж, удирдах зөвлөлд танилцуулан дөрвөн (4) жилийн хугацаатайгаар ажиллуулна.
- 2.5. Загасчлалын спортыг хөгжүүлэх болон МЗСХ-ны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулж, хичээл зүтгэл гаргасныг харгалзан удирдах зөвлөлийн гишүүдээс санал гарган нэр дэвшүүлснээр удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж МЗСХ-ны Хүндэт ерөнхийлөгчийг зарлан, алдаршуулж болно. Хүндэт ерөнхийлөгчийн тоонд хязгаар заахгүй боловч, тус спортын хөгжилд оруулсан хувь нэмэр нь давтагдашгүй үнэт эсэхийг тооцон шийдвэрлэнэ.
- 2.6. Удирдах зөвлөлд Хүндэт ерөнхийлөгчид саналын эрхтэйгээр оролцоно.
- 2.7. Удирдах зөвлөл нь дараах тохиолдолд гишүүдэд өөрчлөлт оруулан томилох, чөлөөлөх эрхтэй. Үүнд:
  - 2.7.1. Гишүүн нас барах
  - 2.7.2. Өөрийн хүсэлтээр гишүүнээс чөлөөлөгдөх (бичгээр)
  - 2.7.3. Гишүүнээс чөлөөлөх болон хасах (гарсан асуудал, ёс зүйн асуудал, хүлээх хариуцлагатай холбоотой тухайн гишүүнд тайлбар хийх боломж олгон түүнийг сонссоны дараа хуралд оролцож буй гишүүдийн гуравны хоёр (2/3)-оос доошгүй саналаар гишүүнээс хасна)
- 2.8. Удирдах зөвлөлийн гишүүд нь гишүүний жилийн хураамжтай байх бөгөөд дараах зохицуулалтыг мөрдөнө. Үүнд:
  - 2.8.1. Удирдах зөвлөлийн саналын эрхтэй бүх гишүүд гишүүний жилийн хураамжийг жил бүрийн 1-р улиралд багтаан МЗСХ-ны дансанд төвлөрүүлнэ. Хураамжийн хэмжээг удирдах зөвлөлийн хурлаар тогтоож, Ерөнхийлөгчийн тушаалаар баталгаажуулсан байна.
  - 2.8.2. Хүндэт ерөнхийлөгчид гишүүний хураамжгүй байна.
  - 2.8.3. Гишүүний хураамжийг энэхүү журамд заасан хугацаанаас хэтрүүлсэн, төлөх боломжгүй болсон тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүнээс хасах асуудлыг энэхүү журмын 2.7.3-т заасны дагуу шийдвэрлэнэ.
- 2.9. Удирдах зөвлөлийн дэргэд дараах тусгайлсан чиг үүрэг бүхий гурван (3) дэд зөвлөл ажиллана. Үүнд:
  - 2.9.1. Цол зэргийн зөвлөл
  - 2.9.2. Тамирчин, тэмцээн уралдааны зөвлөл
  - 2.9.3. Шүүгчдийн зөвлөл.

### Гурав. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Удирдах зөвлөл нь МЗСХ-ны гишүүдийн хурлаар баталсан ерөнхий бодлогын хүрээнд стратеги төлөвлөгөө боловсруулан холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн удирдан зохион байгуулах үүргээ хэрэгжүүлэх бөгөөд МЗСХ-ны гишүүдийн хуралд үйл ажиллагаагаа тайлагнана.

- 3.2. Ерөнхийлөгч болон Ерөнхий нарийн бичгийн дарга нараас боловсруулан оруулж ирсэн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл тайланг хэлэлцэнэ.
- 3.3. МЗСХ-ны санхүүгийн тайлан, жилийн төсөв, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэнэ.
- 3.4. МЗСХ-нд гишүүнээр элсэх хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.5. Ажлын хэсэг болон Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга нараас хууль, дүрэмд нийцүүлэн боловсруулсан дүрэм, журмын төслийг хэлэлцэнэ.
- 3.6. Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын албаны орон тоо, бүтцийг батална.
- 3.7. Тив, ДАШТ-д оролцох шигшээ багийн ерөнхий дасгалжуулагчийг сонгох саналыг холбогдох журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.8. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр болон дүрэм, журмын заалтыг зөрчсөн аливаа үйлдэлд сахилгын шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэнэ.
- 3.9. МЗСХ-ны гишүүдийн хурлаас гаргасан шийдвэр болон дүрэм, журамд заасан бусад үүргийг гүйцэтгэнэ.

#### **Дөрөв. Удирдах зөвлөлийн хурал**

- 4.1. МЗСХ-ны удирдах зөвлөл нь зургаан (6) сар тутамд хуралдана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал хийж болно.
- 4.2. Хурлыг танхим болон цахим хэлбэрээр хийж болно.
- 4.3. Ерөнхийлөгч удирдах зөвлөлийн хурлыг даргална. Ерөнхийлөгч эзгүй болон оролцох боломжгүй тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга хурлыг удирдана.
- 4.4. Удирдах зөвлөлийн хурлыг хоёроос (2) доошгүй хоногийн өмнө гишүүдэд зарлана. Удирдах зөвлөлийн гишүүдэд хурал болох өдөр, цаг, байршил зэрэг мэдээллүүд, хурлаар хэлэлцэх асуудлуудын сэдэв зэргийг мэдээлнэ.
- 4.5. Удирдах зөвлөлийн хурал нь нийт гишүүдийн талаас илүү нь ирсэн тохиолдолд хүчин төгөлдөр байна.
- 4.6. Ирсэн гишүүдийн талаас илүү нь саналаа өгсөн тохиолдолд хурлын шийдвэр хүчинтэйд тооцогдоно.
- 4.7. Санал тэнцсэн тохиолдолд, хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.
- 4.8. Ерөнхий нарийн бичгийн дарга эсвэл түүний эзгүйд хурал даргалагчийн томилсон гишүүн хурлын тэмдэглэлийг хөтлөнө.
- 4.9. Хурлыг дараах дэгийн дагуу явуулна. Үүнд: Ирц бүртгэх, Хурлыг нээх, Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу явуулах, Хэлэлцэж буй асуудлын танилцуулгыг товч тодорхой хийх, Тухайн асуудалтай холбоотой асуулт асууж хариулт өгөх, Санал хэлэх, Хэлэлцсэн асуудлын шийдвэрийг олонхын саналаар шийдвэрлэх, Хурлыг хаах; Хурлын үеэр гар утсаа унтраах, дууг хаах, Түр гарах бол хурал даргалагчаас зөвшөөрөл авах, Асуулт асууж, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэрэглэхгүй байх.

#### **Тав. Ерөнхийлөгч**

- 5.1. Ерөнхийлөгч нь МЗСХ-г дотоодод болон гадаадад төлөөлнө.
- 5.2. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь дөрвөн (4) жил байх ба дахин нэг удаа сонгогдож болно.
- 5.3. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд МЗСХ-г төлөөлж тушаал шийдвэр гарган, гарын үсэг зурна.
- 5.4. Ерөнхийлөгч нь МЗСХ-ны өмч, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргаж, Ерөнхий нарийн бичгийн дарга санхүүгийн баримтад гарын үсэг зурна.
- 5.5. МЗСХ-ны үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор комиссууд болон ажлын хэсэг байгуулж, тэдгээрийг ажлын чиг удирдамжаар ханган ажиллаж болно.
- 5.6. Ерөнхийлөгч тодорхой хугацаанд албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

#### **Зургаа. Ерөнхий нарийн бичгийн дарга**

- 6.1. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дөрөв (4) жилийн хугацаатай томилогдох бөгөөд хугацааг сунган ажиллуулах, дахин томилох боломжтой.
- 6.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь МЗСХ-ны өдөр тутмын үйл ажиллагаа болон ажлын албаны үйл ажиллагааг зохион байгуулах албан тушаалтан байна.

- 6.3. Ерөнхий нарийн бичгийн дарга нь ажлын албыг удирдаж, Гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллана.
- 6.4. Гишүүдийн хурал, Удирдах зөвлөлийн хуралд бэлтгэх, хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцна.
- 6.5. Ерөнхий нарийн бичгийн дарга нь комисс болон ажлын хэсгийн үйл ажиллагааг зохицуулна.
- 6.6. Жил бүрийн тэмцээн уралдааны хуваарийг урьдчилан гаргаж батална.
- 6.7. Бүс, тив, дэлхийн хэмжээний тэмцээн уралдаанд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулан, оролцуулна.
- 6.8. Шаардлагатай тохиолдолд гишүүн холбоод, клубуудыг мэргэжлийн удирдлагаар ханган дэмжлэг үзүүлэн ажиллана.

### **Долоо. Цол зэргийн зөвлөл**

- 7.1. Цол зэргийн зөвлөлийг удирдах зөвлөлийн хурлаас нэр дэвшүүлж, дөрвөн (4) жилийн хугацаатай сонгоно.
- 7.2. Зөвлөлд нэр дэвшигчид үйл ажиллагааг хариуцлагатайгаар явуулах ёс зүйн болон хууль журмын мэдлэг чадвартай байна.
- 7.3. Зөвлөлийн даргыг оролцуулаад таван (5) хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 7.4. Зөвлөлийн сул орон тоог Ерөнхийлөгчийн тушаалаар томилуулна.
- 7.5. Цол зэргийн зөвлөл нь шаардлагатай үед хуралдан дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
  - 7.5.1. Загасчлалын спортын цол, зэргийн шинэчилсэн ангилалын дагуу Олон улсын хэмжээний мастер, Спортын мастер, Спортын дэд мастер, Улсын шүүгч цол зэрэгт нэр дэвшүүлсэн тамирчин, шүүгчдийн материалтай танилцан шалгуурын дагуу хянаж, дүгнэлт гаргах
  - 7.5.2. Шалгуур хангасан, шийдвэр гарган баталгаажуулсан тамирчин, шүүгчийн материалыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллагад тодорхойлон хүргүүлж, спортын цол зэргийг олгуулах
  - 7.5.3. Цол зэргийн шалгуур нөхцөл, түүнтэй дүйцэхүйц үзүүлэлтийн талаар хуралдаж шийдвэр гаргах
- 7.6. Зөвлөлийн нийт гишүүдийн талаас илүү хувь нь санал өгсөн шийдвэр хүчин төгөлдөр байна.
- 7.7. Зөвлөл нь танхим болон цахимаар хуралдаж болно. Мөн саналын хуудсаар шийдвэр гаргаж болно.

### **Найм. Тамирчин, тэмцээн уралдааны зөвлөл**

- 8.1. Тамирчин, тэмцээн уралдааны зөвлөлийг удирдах зөвлөлийн хурлаас нэр дэвшүүлж, дөрвөн (4) жилийн хугацаатай сонгоно.
- 8.2. Зөвлөлд нэр дэвшигчид үйл ажиллагааг хариуцлагатайгаар явуулах ёс зүйн болон хууль журмын мэдлэг чадвартай байна.
- 8.3. Зөвлөлийн даргыг оролцуулаад таван (5) хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 8.4. Зөвлөлийн сул орон тоог Ерөнхийлөгчийн тушаалаар томилуулна.
- 8.5. Тамирчин, тэмцээн уралдааны зөвлөл нь шаардлагатай үед хуралдан дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
  - 8.5.1. Тэмцээн, уралдаан зохион байгуулахтай холбоотой бодлогын болон зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж, чиглэл гаргах
  - 8.5.2. Бүс, тив, дэлхий, улсын хэмжээний тэмцээн уралдааныг зохион байгуулах эсэх санал дүгнэлт гаргах, зохион байгуулалтын багийг бүрдүүлэх, удирдамжаар хангах
  - 8.5.3. Тамирчдын ёс зүйн асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргах, шийтгэвэр гаргах
- 8.6. Зөвлөлийн нийт гишүүдийн талаас илүү хувь нь санал өгсөн шийдвэр хүчин төгөлдөр байна.
- 8.7. Зөвлөл нь танхим болон цахимаар хуралдаж болно. Мөн саналын хуудсаар шийдвэр гаргаж болно.

### **Ес. Шүүгчдийн зөвлөл**

- 9.1. Шүүгчдийн зөвлөлийг удирдах зөвлөлийн хурлаас нэр дэвшүүлж, дөрвөн (4) жилийн хугацаатай сонгоно.

- 9.2. Зөвлөлд нэр дэвшигчид үйл ажиллагааг хариуцлагатайгаар явуулах ёс зүйн болон хууль журмын мэдлэг чадвартай байна.
- 9.3. Зөвлөлийн даргыг оролцуулаад таван (5) хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 9.4. Зөвлөлийн сул орон тоог Ерөнхийлөгчийн тушаалаар томилуулна.
- 9.5. Шүүгчдийн зөвлөл нь шаардлагатай үед хуралдан дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
  - 9.5.1. Бүс, тив, дэлхий, улсын хэмжээний тэмцээн уралдааны ерөнхий шүүгч, шүүгчдийн бүрэлдэхүүнийг санал оруулж, томилох
  - 9.5.2. Тэмцээн уралдаануудын ерөнхий шүүгч, шүүгчийн бүрэлдэхүүнд зөвлөлийн гишүүдээс оролцон ажиллах
  - 9.5.3. Тэмцээн уралдаануудын дүн бодолтыг хийх, эсвэл хяналт тавьж баталгаажуулах
  - 9.5.4. Улсын шүүгчид нэр дэвшүүлэх, болзол хангасан шүүгч дээр дүгнэлт гаргах
  - 9.5.5. Тэмцээн уралдаантай холбоотой шүүлтийн маргаан, шүүгчийн асуудал, ёс зүйн асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах
- 9.6. Зөвлөлийн нийт гишүүдийн талаас илүү хувь нь санал өгсөн шийдвэр хүчин төгөлдөр байна.
- 9.7. Зөвлөл нь танхим болон цахимаар хуралдаж болно. Мөн саналын хуудсаар шийдвэр гаргаж болно.